

Батлав:

_____/ Г.ЭНХМӨНХ /
БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодолгын
хэрэгжилтийн газрын дарга

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

_____/ Ч.ИХБАЯР /
"Их онь" ХХК-ийн гүйцэтгэх захирал



**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН 7-Р БАГИЙН НУТАГТ
ИХ ОНЬ ХХК-ИЙН "НООС, НООЛУУРЫН ҮЙЛДВЭР"-ИЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 3431045/

Хянасан:

ХБОБЗГ-ын ахлах шинжээч _____ / _____ /

Боловсруулсан: "Их онь" ХХК-ийн

байгаль орчны мэргэжилтэн Б.Ганчимэг /Б.Ганчимэг/

2024 он

Агуулга

1	НООС НООЛУУРЫН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	1
1.1	Төслийн танилцуулга	1
1.2	Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи	2
1.3	Үйлдвэрийн талбай, барилга байгууламж	6
1.4	Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж	7
1.5	Усан хангамж.....	8
1.6	Хог хаягдал.....	9
2	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	10
2.2	Уур амьсгал	10
2.3	Агаарын чанар.....	13
2.4	Физик бохирдол.....	15
2.5	Геологийн тогтоц ба геоморфологи	15
2.6	Газрын доорх ус.....	16
2.7	Хөрсөн бүрхэвч.....	16
2.8	Ургамлан нөмрөг	16
2.9	Амьтны аймаг	17
2.10	Тусгай хамгаалалттай газар нутаг	17
2.11	Түүх, соёлын өв.....	17
2.12	Нийгэм, эдийн засаг	18
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	21
3.1	Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	21
3.2	Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	21
3.3	Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	21
3.4	Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	21
3.5	Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	21
3.6	Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.7	Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.8	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.9	Дуу шуугианаас үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.10	Нийгэм, эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.11	Түүх, соёлын өвд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	22
4	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	23
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	25
6	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	31
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	32
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	33
8.1	Баримтлах эрх зүйн баримт бичиг.....	33
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	36
10	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	37
11	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө.....	39

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал	2
Хүснэгт 2: Үйлдвэрийн усан хангамж	8
Хүснэгт 3. Хатуу хог хаягдлын тооцоо	9
Хүснэгт 4. Судалгааны талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүн	14
Хүснэгт 5. Судалгааны талбайн ойролцоо орших орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын талаарх мэдээлэл	17
Хүснэгт 6. “Ноос, ноолуурын үйлдвэр”-ийн 2024-2028 оны БОМТ-ний нийт зардал	23
Хүснэгт 7: 2024 оны БОМТ-ний нийт зардлын хэмжээ	23

Хүснэгт 8: “Ноос, ноолуурын үйлдвэр”-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, 2024 он.....	25
Хүснэгт 9: Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө, 2024 он.....	31
Хүснэгт 10: Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, 2024 он.....	34
Хүснэгт 11: Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө, 2024 он.....	36
Хүснэгт 12: “Ноос, ноолуур үйлдвэрийн”-ийн 2024 онд хэрэгжүүлэх ОХШХ.....	37
Хүснэгт 13: “Ноос, ноолуур үйлдвэр”-ийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	39

Зургийн жагсаалт

Зураг 1. Үйлдвэрийн талбайн байршил	1
Зураг 2. Төслийн талбайн байршлын агаар сансрын зураг	2
Зураг 3. Ноос угаах үйлдвэрийн технологийн дамжлага.....	3
Зураг 4. Сэгсрэх машин	4
Зураг 5. Угаах машин	5
Зураг 6. Үйлдвэрийн барилгын ерөнхий төлөвлөгөө.....	6
Зураг 7. Үйлдвэрийн харагдах байдал.....	7
Зураг 8. Үйлдвэрийн талбайд байрлах дэд станц	7
Зураг 9. Үйлдвэрийн нам даралтын зуух, DZH- 1.25-AII, 1.25 MPa.....	8
Зураг 10. Дундговь аймгийн Мандалговь хотын климаграмм.....	10
Зураг 11. Агаарын дундаж температурын явц, жилээр	11
Зураг 12. Агаарын дундаж температурын явц, сараар.....	11
Зураг 13. Харьцангуй чийгшлийн явц, сараар	12
Зураг 14. Жилийн нийлбэр хур тунадасны явц	12
Зураг 15. Хур тунадасны явц, сараар	13
Зураг 16. Салхины зонхилох чиглэл	13
Зураг 17. PM2.5 тоосонцрын хэмжилтийн үр дүн.....	14
Зураг 18. PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн.....	14
Зураг 19. Судалгааны талбай түүний орчмын геологийн зураг	16

1 НООС НООЛУУРЫН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1 Төслийн танилцуулга

Их онь ХХК-ийн ноос ноолуурын үйлдвэрийн талбай нь Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт оршино. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр нь Мандалговь хотоос зүүн урд зүгт ойролцоогоор 700 м зайд байрлана

Их онь ХХК нь 2012 онд байгуулагдсан ба 2017 оноос хонь, тэмээний ноосыг угаах, самнах үйлдвэрийг ашиглалтад оруулан ажиллаж байна. Жилдээ 300-3600 тн хонь, тэмээний ноос угаах, 100-120 тн хонь, тэмээний ноос самнах хүчин чадалтай. Тус үйлдвэр нь 2024 онд үйлдвэртээ орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос, ноолуур угаах тоног төхөөрөмжүүд, цэвэрлэх байгууламжийг суурилуулан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн нэр: “Ноос, ноолуурын үйлдвэр”


Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Их онь” ХХК

Регистрийн дугаар: 3431045

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг, Нарлаг, 13-р байр.
Утас: 99599999

Төслийн талбайн байршил

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбай нь Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р багийн нутаг дэвсгэрт 6516 м² газарт оршино (Зураг 1).



Зураг 1. Үйлдвэрийн талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн байршлын агаар сансрын зураг

1.2 Үйлдвэрийн хүчин чадал, техник технологи

Үйлдвэрийн хүчин чадал


Их онь ХХК нь 2012 онд байгуулагдсан ба 2017 оноос хонь, тэмээний ноосыг угаах, самнах үйлдвэрийг ашиглалтад оруулан ажиллаж байна. Жилдээ 3600 тн хонь, тэмээний ноос угаах, 120 тн хонь, тэмээний ноос самнах хүчин чадалтай.

Хүснэгт 1: Үйлдвэрийн хүчин чадал

№	Түүхий эд	Жилд ажиллах хоног	Хүчин чадал, тн		Ажиллагсдын тоо, хүн
			Хоногт	Жилд	
1	Хонь, тэмээний ноос угаах	250	14.4	3600	38
2	Хонь, тэмээний ноос самнах		0.5	120	

Үйлдвэрийн технологи

Ноос угаах үйлдвэр нь сэгсрэх, авто тэжээх, угаах, хатаах, преслэх гэсэн технологийн үндсэн дамжлагуудтай бөгөөд эдгээр нь өөр хоорондоо хийн тээврийн хоолойгоор холбогдож нэг агрегат шугам болдог.



Зураг 3. Ноос угаах үйлдвэрийн технологийн дамжлага

Сэгсрэх машины бүтэц ажиллагаа

Сэгсрэх ажиллагааны зорилго нь ноос болон бусад төрлийн ширхэгт хаг, хогт хольцоос нь цэвэрлэхэд оршино. Сэгсрэх машин нь ноос, ноолууран ширхэгтэд цохин сэгсрэх, сэмлэн бутлах үйлчилгээг зэрэг үзүүлдэг бөгөөд гол барабаны зүүнүүд нь цилиндр, конус, хагас бөмбөлөг хэлбэртэй, гөлгөр гадаргуутай байх ба хаг хог, зунгаг багатай ноосон ширхэгтийг боловсруулахад тохиромжтой байдаг.

Сэгсрэх үйл ажиллагааны үр дүнд технологийн шаардлага хангаагүй богино ширхэгтүүд, ургамлын ба эрдсийн гаралтай хольцуудыг агуулах хаг, хог хаягдлууд 3-20% ялгардаг байна. Энэ нь ширхэгтийг угаах уусмалын зарцуулалт ба онгоцонд хуримтлагдах хаягдлын хэмжээг багасгах. ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт давуу талуудтай. Жишээ нь сэгсрээгүй 100 кг нарийн ноосыг угаахын тулд 9 кг саван зарцуулагдах бол сэгсэрсэнд ойролцоогоор 6 кг саван зарцуулдаг.



Зураг 4. Сэгсрэх машин

Задлах, сэгсрэх машины эд ангиуд (шүдтэй гадаргатай) ноосны багц хэсгүүдэд хүчтэй цохилтын хүчээр үйлчилсний дүнд тэдгээр нь туг үснүүд болон задрахын зэрэгцээ хогт хольц нь салж цэвэрлэгддэг.

Сэгсрэх ажиллагаа хуурай нөхцөлд явагдвал цахилгаанжилт үүсэж тоосжилт ихсэхээс гадна машины гадаргууд ноолуур наалдаж уг ажиллагааг хүндрүүлдэг. Ажлын байранд 70-75%-ийн харьцангуй чийгшилтэй орчин бүрдүүлэх нь чухал.

Авто тэжээгчийн бүтэц, ажиллагаа

Угаах машины өмнө түүнд ноос, ноолуурыг тасралтгүй жигд өгөх зориулалттай авто тэжээгч (угаах машиныг автоматаар тэжээх машин) байрлана. Ноос угаах агрегат нь ихэнх тохиолдолд хоёр авто тэжээгчтэй бөгөөд нэг нь бохир ноос, ноолуурыг сэгсрэх машинд өгөх, нөгөө нь хатаах машиныг угаагдсан ноос, ноолуураар тэжээх зориулалттай.

Угаах агрегатын автотэжээгч: Авто тэжээгчийн тэжээх ба гаргах хэсэг нь өөр хоорондоо нугасаар холбогдсон металл хавтангуудаас тогтоно. Ажлын эд ангийн гадаргууд ган шүднүүд тавлагдан

хадагдсан байна. Автомат тэжээгч нь жигдрүүлэгч ба хуулах самнуудтай. Зүүн шүдэт дамжуулагч ба сам хоёрын хоорондох зайг тэжээгчийн зүүн талд байрлах хүрдээр тохируулна. Авто тэжээгч нь ноосны авдар, тэжээх хэвтээ дамжуулагч, босоо чигт байрласан зүүн шүдэт дамжуулга гэсэн үндсэн эд ангиудаас тогтоно. Зүүн шүдэт дамжуулагч нь дээд голд хөдөлгөөнийг дамжуулна. Энэ голоос хөдөлгөөнийг хурдны хайрцаг авна.

Зүүн шүдэт дамжуулагчийн доод хэсгээр бохирдлогын зүйлийг холдуулагч байрласан байна. Зүүн шүдэт дамжуулагч нь ноос, ноолуурыг өөрийн шүдээр хаман авах бөгөөд жигдрүүлэгч сам нь ноос, ноолуурын үеийг жигдрүүлж өгөхөөс гадна энэ хоёрын хооронд ноосны бүхэл хэсэг, бохирдлогын зүйлс жижиглэгдэнэ. Жигдрүүлэгчийн ба дамжуулагчийн хоорондох зай самны хэлбэлзэх далайцын хэмжээг тохируулж болно. Хуулах барабан нь өөрийн хавтгай хэлбэртэй зүүгээр ноос, ноолуурыг цохин сэгсрэх машины тэжээх рещеток дээр унагана.

Авто тэжээгч нь ноос, ноолуурыг авдрандаа тогтмол хэмжээтэй барьж байдаг автомат механизмаар тоноглогдсон байдаг. Авдар нь 1.4 м³ багтаамжтай байдаг. Босоо зүүн шүдэт дамжуулагч нь дөрвөн янзын хурдтай бөгөөд энэ нь 11.25, 8.8, 6.95, 5.05 м/мин байна. Хэвтээ тэжээх дамжуулагчийн хурд нь 4.53, 3.58, 2.83, 2.06 м/мин гэсэн гурван өөр хурдтай байна. Гаргах дамжуулагч нь 6.8 м/мин хурдтай байна.

Угаах машины үйл ажиллагаа

Угаах ажиллагааны зорилго нь түүхий эдийг технологийн горимын дагуу, техникийн нөхцөлд нийцүүлэн дэвтээх (норгох), савангийн уусмалаар угаах (бохирдлогыг арилгах), зайлах (үлдэгдэл савангийн уусмал болон бохирдлогыг ноосон ширхэгтээс салгаж зайлуулах) зэрэг ажиллагаануудын үр дүн бөгөөд стандартаар тогтоогдсон физик-химийн тодорхой шинж чанартай угаасан ноосон ширхэгт гаргаж авахад оршино.


Үйлдвэрлэлд ашиглагдах ус нь техникийн шаардлагад нийцсэн байна. Усны хатуулаг нь бага байх: Ноос, ноолуур угаахад зөөлөн ус хэрэглэнэ. Үүнд усны хатуулаг нь 2-3 мг-экв/л байна. Цэвэр ус 25°C (77 T)-д рН=7 байхад хэвийн байна гэж үздэг.



Зураг 5. Угаах машин

1.3 Үйлдвэрийн талбай, барилга байгууламж

- Ноос угаах, самнах үйлдвэрлэлийн барилга нь 130 м урт, 15 м өргөн, 4 м өндөртэй, 1950 м² талбайтай,
- Оффисын байр 10 х 25 м, 250 м² талбайтай,
- Агуулахын барилга нь 60 м урт, 27 м өргөн 6 м өндөртэй, 1620 м² талбайтай,
- Цэвэрлэх байгууламж 10 х 30 м, 300 м² талбайтай,
- Хоолны газар
- Ажиллагсдын хувцас солих, амрах
- Ариун цэврийн болон бойлерын өрөөнүүдтэй,
- Харуул, хамгаалалтын байртай, эдгээр нь үйлдвэрлэлийн барилгын хамт халуун, хүйтэн ус, дулааны шугам хоолойд холбогдоно.



Зураг 6. Үйлдвэрийн барилгын ерөнхий төлөвлөгөө

Хатуу хог, хаягдлын цэгтэй, үйлдвэрийн барилгын талбайн 20%-иос багагүй хувь нь ногоон байгууламжтай байхаас гадна шөнийн гэрэлтүүлэгтэй, үйлдвэрийн дотор, гадна орчны камержуулалт, дохиолол, харуул хамгаалалтын системтэй байна.

Үйлдвэрийн барилга нь сэндвичэн бүтээцтэй, дулааныг гадагш алдагдуулахгүй байх технологи ашигласан байна.





Зураг 7. Үйлдвэрийн харагдах байдал

1.4 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбайд 6кв/0.4кв-ын цахилгааны дэд станцтай бөгөөд мэргэжлийн байгууллагаар зураг төсвийн дагуу монтаж хийлгэсэн. Үйлдвэр нь жилд дунджаар 12,320 кВт цахилгаан зарцуулна.



Зураг 8. Үйлдвэрийн талбайд байрлах дэд станц

Төлөвлөж буй үйлдвэр нь бага оврын нам даралтын зуухаар үйлдвэрийн барилга байгууламжийг халаахаас гадна үйлдвэрийн технологид шаардлагатай уур болон халуун усаар хангана. Өдөрт 1000 кг нүүрс түлнэ.



Зураг 9. Үйлдвэрийн халаалтын зуух

1.5 Усан хангамж

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээг ("Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан **"Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"**-ын 4 дугаар хавсралт "Хөнгөн үйлдвэрийн ус хэрэглээний норм"-д зааснаар 1 тн ноос угаахад 43 м³ ус зарцуулна. Бүрэн хүчин чадлаараа хамгийн ихдээ 14.4 тн ноос угаана гэж үзэн, төслийн ажиллах хугацаа /жилийн 250 хоног/-нд:

- Унд ахуйн хэрэгцээнд: 38 хүн x 150 л/хоног=5.7 м³/хоног x 250 хон = 1425 м³/жил,
- Технологийн хэрэгцээнд (ноос угаах) 14.4 тн/хон 43 м³/тн =619.2 м³/хон x 250 хон = 154,800 м³/жил

Үйлдвэрийн талбайд нийт 30 ш суулгац тарих ба 13 дугаар хавсралт "Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм"-д зааснаар 1 ш суулгац услахад **40 литр** ус зарцуулна /жилийн 5-10 сарын хугацаанд 12 удаа/-нд:

- 30 ш суулгац x 40 л ус x 12 удаа = 14.4 м³/ус

Хүснэгт 2: Үйлдвэрийн усан хангамж

#	Усны хэрэглээний нэр	Усны зарцуулалт, м ³	
		Хоногт	Жилд
1	Унд ахуйд	5.7	1,425
2	Технологийн хэрэгцээнд (ноос угаах)	619.2	154,800
3	Мод усалгаанд	0.06	14.4
Дүн		626.1	156,239.4

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн унд ахуй болон технологийн хэрэгцээний усыг Дундговь аймгийн төвлөрсөн ус хангамжийн системээс хангана. Их онь ХХК нь цэвэр, бохир усны төвлөрсөн системд холбох техникийн нөхцөл гаргуулан цэвэр, бохирын шугамын холболтыг хийлгэсэн.

1.6 Хог хаягдал

Хог хаягдлыг ерөнхийд нь аливаа үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд шууд нийцэхгүй болсон материал гэж тодорхойлдог (OECD, 2003). Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад дор дурдсан гарал үүсэлтэй хог хаягдал гарна. Үүнд:

- Ахуйн гаралтай хаягдал
- Ноос сэгсрэх үйл ажиллагаанаас үүсэх ургамлын болон хогт хольцууд
- Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал

Ахуйн гаралтай хог хаягдал

Хатуу хог хаягдал

Ахуйн гаралтай хог хаягдалд үйлдвэрийн ажилчдын хэрэглээнээс гарах хоолны үлдэгдэл, цэнэг хураагуур, хаягдал цаас, хайрцаг, шилэн сав, лонх, хуванцар сав, хуванцар эдлэл, даавуун болон нийлэг эдлэл гэх мэт хаягдлууд орно.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт 38 хүн ажиллана гэж тооцоход.

Хүснэгт 3. Хатуу хог хаягдлын тооцоо				
Нийт хоног/жилд хоног,	ажиллах	Ахуйн хог хаягдал, кг	Нийт хүний тоо	Нийт, кг/жил
250		0.5	38	4750

Дээрх хүснэгтээс харахад тус үйлдвэрийн ажилчдаас жилд ойролцоогоор 4.8 тн ахуйн хог хаягдал гарахаар байна.

Ноос ноолуур боловсруулах үйл ажиллагаанаас дунджаар 15%-ийн хогт хольц гарна гэж тооцоход жилд ойролцоогоор 540 тн гарахаар байна.

Ахуйн хог хаягдлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумтай хог ачилт, тээвэрлэлтийн гэрээ хийн тогтмол хугацаанд ачуулах ба тухайн газрын зөвлөсөн хогны бункерийг хашаандаа байрлуулна.

Шингэн хог хаягдал

Ноос угаах үйл үйл ажиллагаа болон үйлдвэрийн ажилчдын ахуйн шингэн хаягдал, ажилчдын гал тогооноос үүсэх ахуйн бохир ус зэрэг шингэн хаягдлууд үүснэ.

Үйлдвэрийн болон ахуйн хэрэгцээнд хоногт нийт 626.1 м³ ус хэрэглэнэ. Үүнээс 100%-ийг хаягдал ус гэж үзвэл: Жилд 626.1 м³/хоног * 250 хоног = 156,239.4 м³/жил болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь Хаанзаа ХХК-ийн цэвэрлэх байгууламжийг суурилуулсан. Ноос угаах үйлдвэрийн урьдчилсан цэвэрлэх байгууламжийг тоног төхөөрөмжүүд, гүйцэтгэгчийн модульчлагдсан танкууд БНЧУ-аас нийлүүлэгдсэн (Зураг 2.8). Санал болгож буй цэвэрлэх байгууламж нь технологийн хаягдал усны чанарыг "Ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилсан цэвэршүүлсэн бохир усны техникийн шаардлага. MNS 6390:2013" болон "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэгдэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561 : 2015" стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэнэ.

Ноос ноолуур боловсруулах үйлдвэрийн бага оврын цэвэрлэх байгууламжаас гарах усыг Дундговь аймгийн бохирын төвлөрсөн системд нийлүүлэх бөгөөд шугамын холболтыг хийлгэсэн.

2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Дундговь аймгийн төв Мандалговь хот нь Улаанбаатар хотоос урд зүгт 260 км зайд Монгол орны төвийн хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсэд багтана. Мандалговь хот нь хойд талаараа тэвшийн говь, баруун талаараа Улаан толгойн говь, зүүн талаараа Төгрөгийн тал, урд талаараа Дэртийн хөндий зэрэг томоохон хөндийнүүдээр хүрээлэгдэнэ. Мандалговь хотыг тойрсон говийн намхан уулс, толгодуудын үнэмлэхүй өндөр дтд 1400-1560 байдаг. Эргэн тойрны уулсаас хамгийн өндөр нь аймгийн төвийн баруун хойд талд байрлах Зоогийн хар овоо дтд 1563.3 м уул юм. Хамгийн нам доор цэг нь аймгийн төвийн зүүн урд талын давстай тойрмын орчим дтд 1350 м байдаг. Мандалговь хотыг тойрсон толгодууд нь Сэнстийн гүвээ, Улаан толгой, Хүрэн толгой, Энгэр улаан толгой, Цагаан чих, Цуваа улаан, Хөх дэрсний улаан, ширүүн гүвээ, Ламын дэнж зэрэг нэрүүдтэй ба сансраас авсан зургаас харахад цайвар бор, бор хүрэн өнгөөр ялгардаг.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбайн баруун талд Улаан толгой уул дтд 1479 м, хойд талаараа Энгэр улаан уул дтд 1512 м, зүүн талаараа Хөх дэрсний улаан уул дтд 1464 м, урд талаараа Ширүүн гүвээ дтд 1392 м өргөгдсөн ба орчны гадаргатай харьцангуй өндрийн ялгаа 30 м орчим байна. Мөн урд хэсгээр нь нисэх онгоцны зурвас газар байрлана. Судалгааны талбайн талбайн үнэмлэхүй өндөр 1413-1416м ба урдаас хойш өндөрсөж тогтсон гадаргатай.


2.2 Уур амьсгал

Дундговь аймгийн Мандалговь хотын уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. 1999-2022 оны цаг агаарын ажиглалтын мэдээнээс үзэхэд энэ бүс нутгийн жилийн дундаж агаарын температур 2.95°C , хөрсний гадаргын дундаж температур 5.5°C байна. Агаарын харьцангуй чийгшил дунджаар 50%, жилд унах нийт хур тунадасны хэмжээ дунджаар 132.2 мм хүрдэг (Зураг 10). Энэ бүс нутагт салхины дундаж хурд 4.8 м/с хүрдэг бөгөөд хойд, баруун хойд зүгийн салхи зонхилдог.




Зураг 10. Дундговь аймгийн Мандалговь хотын климаграмм

Агаарын температур: 1980-2022 оны ажиглалтын мэдээгээр Улаанбаатар хотын агаарын 1999-2022 оны ажиглалтын мэдээгээр агаарын үнэмлэхүй хамгийн бага температур нь -35.9°C (2021.1), үнэмлэхүй хамгийн их температур нь 39.6°C (1999.07) тус тус хүрсэн байна. Агаарын дундаж температур 2.95°C байна (Зураг 11).



Зураг 11. Агаарын дундаж температурын явц, жилээр


Жилийн хамгийн хүйтэн үе нь 1-р сар (-17.3°C), хамгийн халуун үе нь 7-р сар (21.3°C) байдаг (Зураг 12).



Зураг 12. Агаарын дундаж температурын явц, сараар


Хур тунадас, чийгшлийн горим

Энэ бүс нутагт агаарын харьцангуй чийгшил 50% байна. Харьцангуй чийгшлийн хамгийн их утга нь 8-р сард 62.9%, харин хамгийн бага утга нь 4-р сард 39.0% хүрдэг (Зураг 13).




Зураг 13. Харьцангуй чийгшлийн явц, сараар

Мандалговь цаг уурын өртөөний 1999-2022 оны хур тунадасны мэдээнээс үзэхэд тус бүс нутгийн жилийн дундаж нийлбэр хур тунадас нь 132.2 мм байна (*Зураг 14*).



Зураг 14. Жилийн нийлбэр хур тунадасны явц

Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд дунджаар 82.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 69.5% нь унадаг байна (*Зураг 15*).




Зураг 15. Хур тунадасны явц, сараар

Агаарын даралт, салхины горим

Энэ бүс нутгийн салхины дундаж хурд 4.8 м/с хүрдэг. Салхины хурд хавар, намрын улиралд ихсэж, өвөл, зуны улиралд багасдаг. 1999-2022 оны хугацаанд энэ бүс нутагт салхины их хурд 2009 оны 12-р сард 40 м/с хүрсэн.

Салхины чиглэлийн мэдээнээс үзэхэд энэ бүс нутагт хойд, баруун хойд зүгийн салхи зонхилж байна.



Зураг 16. Салхины зонхилох чиглэл


2.3 Агаарын чанар

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандарт (MNS 4585:2016) болон Дэлхийн банкны хүрээлэн буй орчны агаарын чанарын удирдамж (IFC)-тай харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 4).


Хүснэгт 4. Судалгааны талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүн

#	Байршил	Координат		Дуу шуугиан, дБА	PM 2.5	PM10
		Өргөрөг	Уртраг		мкг/м ³	
1	Ноос, ноолуур болвсруулах үйлвэрийн талбайн урд	106°16'25.22"	45°45'26.59"	51	4	2
MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (24 цагийн дундаж)				60	50	100
IFC удирдамж (24 цагийн дундаж)					25	50

Дээрх хүснэгтээс харахад PM10 тоосонцор болон PM2.5 тоосонцрын агууламж MNS 4585:2016 стандарт болон Дэлхийн банкны хүрээлэн буй орчны агаарын чанарын удирдамж (IFC)-д заасан хүлцэх агууламжаас бага түвшинд байна. Дуу шуугианы түвшин MNS 4585:2016 стандартад заасан хэмжээнээс бага байна (Зураг 17, Зураг 18).



Зураг 17. PM2.5 тоосонцрын хэмжилтийн үр дүн



Зураг 18. PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн

2.4 Физик бохирдол

Дуу шуугиан

ДЭМБ-ын гаргасан лавлахад шуугианы түвшин суурьшлын орчинд 16 цагийн хугацаанд 50-55дБА, үйлдвэр, олон нийтийн үйлчилгээний газар, автозамын дагуу 24 цагийн турш 70дБА байхад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Эрүүл ахуйн үүднээс хүн өдөрт тасралтгүйгээр байж болох шуугианы зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоон мөрддөг.

Монгол Улсын MNS 4585:2016¹ стандартад заасанчлан өдрийн цагт 60 дБА (16 цагийн дунджаар), шөнийн цагаар 45 дБА (8 цагийн дунджаар)-аас хэтрүүлэхгүй байх ёстой бол Олон улсын IFC² стандартад зааснаар гадаад орчны дуу чимээ өдрийн цагаар 55 дБА, шөнийн цагаар 45 дБА-аас давахгүй байхыг заасан байдаг. Мөн ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй хөдөө нутагт дуу шуугианы түвшин дунджаар 30 дБА³ байдаг.

Монгол улсад анх 1996 онд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн гадаад орчны дуу шуугианыг судлахад Улаанбаатар хотын гудамжны дуу шуугианы дундаж түвшин (ДШДТ) 71дБА байсан. Түүнчлэн 2003 оны Монгол улсын томоохон хотуудын дуу шуугианы түвшингийн судалгаагаар дундаж түвшин 63.6 дБА байсан ба УБ хотын төв гудамжны дуу шуугианы оргил үе нь 08-09 цагт байна /НЭМХ, 2003/. Дуу шуугианы түвшин өндөртэй орчинд олон жил амьдарсан болон ахимаг настай хүмүүс дуу шуугианд илүү өртдөг бөгөөд үүнд авто машинаас гарах дуу шуугиан их нөлөөлдөг нь тогтоогдсон байна.

Хэвийн хэмжээнээс хэтэрсэн дуу шуугиан нь хүний сонсгол болон тархины эд эсүүдийг гэмтээж, төв мэдрэлийн системд нөлөөлснөөр түргэн ядрах, анхаарал сулрах, нойргүйдэж улмаар зүрх судасны үйл ажиллагаанд өөрчлөлт орж, даралт ихсэх, зүрхний шигдээс өвчний эрсдэлийг нэмэгдүүлэх, бодисын солилцоо болоод ходоод гэдэсний хэвийн ажиллагаа алдагдах зэргээр хүний эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Судалгааны талбайд тогтмол дуу шуугианы эх үүсвэр байхгүй бөгөөд харин талбайн зүүн талаар 250 м зайд байрлах Улаанбаатар – Дундговь- Өмнөговь чиглэлийн авто замаар зорчих тээврийн хэрэгслээс шуугианы нөлөөлөл үзүүлж болно. Барилгажилтын үед ажиллах машин механизм, техник хэрэгслээс дуу шуугиан үүсэж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.


Хог хаягдал

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбайд ноос, ноолуур угаах, самнах зориулалттай үйлдвэрийн барилга баригдсан байна. Энгийн хатуу хог хаягдлыг судалгааны талбайд байрлах хогийн цэгт түр байршуулдаг. Өөрийн эзэмшлийн талбай болон ойр орчмын талбай нь хог хаягдлаар бохирдоогүй байв.

Шингэн хог хаягдлыг Дундговь аймгийн бохирын төвлөрсөн системд нийлүүлэхээр холболт хийгдсэн байв. Үйлдвэрийн барилгыг өргөтгөх, ашиглах явцад хатуу, шингэн хог хаягдал гарна.

2.5 Геологийн тогтоц ба геоморфологи

Мандалговь хот, түүний орчмын талбайн хэмжээнд хурдас хуримтлалын олон төрлүүд байдаг. Мандалговь хот болон ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбай нь доод цэрдийн настай тунамал хувирмал хурдас, доод пермийн настай нэлээд атираажилтад автсан хувирмал чулуулаг, пермийн настай гүний чулуулгийн хил заагт байрладаг. Төсөл хэрэгжих талбай орчим нь үндсэн чулуулгийн гарш ихтэй, дөрөвдөгч болон орчин үеийн хурдас хуримтлал нимгэн нутаг байна. Судалгааны талбайн урд талд юрагийн настай хурдас хагарлаар зааглагдаж, тасарч үлдсэн байна.



Зураг 19. Судалгааны талбай түүний орчмын геологийн зураг

2.6 Газрын доорх ус

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн унд ахуй болон технологийн хэрэгцээний усыг Дундговь аймгийн төвлөрсөн ус хангамжийн системээс хангана.

Усны шинжилгээний үр дүнг Монгол улсын Ундны усны стандарт MNS 0900:2018-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс усан дахь магнийн агууламж 42.4 мг/л-ээр, хатуулаг 3.25 мг/л-ээр тус тус их гарсан байна.

2.7 Хөрсөн бүрхэвч

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбай орчимд сайргархаг цайвар хүрэн хөрс тархсан. Хөрсний үржил шимт үеийн дундаж зузаан 15 см, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ялзмагийн агууламж 1% бөгөөд хөрсний үржил шимийн ерөнхий түвшин багатай байна.

Хөрсний хүнд металлын дээжид хийсэн лабораторийн шинжилгээгээр хөрсөн дэх хүнцэлийн агууламж 6 мг/кг гарсан нь MNS 5850:2008 (Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад хүнцэл 4 мг/кг-аар өндөр гарсан бол бусад элементүүдийн хувьд тус стандартын ЗДХ-нээс хэтэрсэн үзүүлэлт илрээгүй.

2.8 Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь хүний болон техникийн нөлөөлөлд бүрэн өртөн халцарч ургамалгүй болсон байна. Зөвхөн зүүн хойд болон баруун хэсгийн 0.05 га талбайд бэлчээрийн талхагдлыг илэрхийлэгч хөл газрын ургамал болох Ээрэм шарилж (царван) (*Artemisia macrocephala*), Царвант шарилж (*Artemisia macrocephala*), Адамсын шарилж (*Artemisia Adamsii*), Цагаан лууль (*Chenopodium album*) зэрэг ургамлууд зонхилон ургасан байна.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ халцарч ургамалгүй болсон тул барилгын болон ашиглалтын үед нөлөөлөлд өртөх ургамлан нөмрөг байхгүй. Иймээс төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

2.9 Амьтны аймаг

Судалгааны талбай, түүний орчим нь барилгажсан төдийгүй авто зам, хотжилтын нөлөөлөлд өртсөн тул төлөв байдлын судалгаагаар мөлхөгч, шувуу, хөхтөн амьтад болон тэдгээрийн үл мөр, нүх оромж тохиолдоогүй. Дундговь аймгийн 2017 оны Агнуур зохион байгуулалтын болон Байгаль орчны төлөв байдлын судалгаа (2017)-гаар хөхтөн амьтад (Аргаль хонь, Янгир ямаа, Хар сүүлт, Цагаан зээр, Монгол тарвага, Саарал чоно, Шар үнэг, Хярс үнэг, Бор туулай) болон зарим шувууд (Монгол ногтруу, Дагуур ятуу)- нарийвчлан судалсан ба тус судалгааг ШУА-ийн Биологийн хүрээлэн, Хөхтний экологийн лаборатори, Дундговь аймгийн БОАЖГ болон сумдын байгаль орчны улсын байцаагчид хамтран гүйцэтгэсэн байна.

2.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Судалгааны талбайн ойролцоо Дундговь аймгийн тусгай хамгаалалтад авсан нэг, Сайнцагаан сумын тусгай хамгаалалтад авсан гурван газар байна.

Хүснэгт 5. Судалгааны талбайн ойролцоо орших орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын талаарх мэдээлэл

#	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нэр	Судалгааны талбай хүртэлх зай, км	Хамгаалалтад авсан үндэслэл	Хамгаалалтад авсан тогтоолын дугаар	Талбайн хэмжээ, га
Дундговь аймгийн тусгай хамгаалалттай газар					
1	Олгойн говь 1, 2-р хэсэг	25.2	Ой, амьтан, ургамал, усны нөөц газар	Дундговь аймгийн ИТХ, 2016/01/29, 15-р тогтоол	6657.25
Сайнцагаан сумын тусгай хамгаалалттай газар					
2	Хадагт, Бутат овоо, Зоогийн жасын овоо, Алтат	2.4	Байгаль, түүхийн дурсгалт газар	Дундговь аймгийн ИТХ, 2015/12/17, 8-р тогтоол	20633.68
3	Тогоогийн рашаан, Тогоогийн хужир, Хүйтэн булаг	16.1	Байгаль, түүхийн дурсгалт газар	Дундговь аймгийн ИТХ, 2015/12/17, 8-р тогтоол	32272.35
4	Сайнцагаан уул, Авдрангын хөнхрийн хөшөөт, Хөрх	4.4	Байгаль, түүхийн дурсгалт газар	Дундговь аймгийн ИТХ, 2015/12/17, 8-р тогтоол	99101.56

Эх сурвалж: <http://eic.mn/spa/gis.php>

2.11 Түүх, соёлын өв

Монгол улсын "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн 17.3.-т "Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн эрх зүйн хамгаалалтыг улсын, орон нутгийн, байгууллагын гэж ангилдаг. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан уг жагсаалтад Дундговь аймагт 7 дурсгалыг улсын хамгаалалтад, 16 дурсгалыг аймгийн хамгаалалтад авахаар оруулсан байна. Үүнд:

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Адаацаг сумын нутагт орших Сүм Хөхбүрдийн балгас
2. Баянжаргалан сумын Хүрэн духын палеонтологийн дурсгалт газар
3. Гурвансайхан сумын Ярх ууланд орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
4. Өлзийт сумын Баруун билүүт ууланд орших хадны зураг, руни бичээс
5. Өлзийт сумын Дэл уулын Хамар ус, Гучин хоёр хүн хөшөөт хэмээх газар орших хадны зураг, буган чулуун хөшөө цогцолбор дурсгал
6. Эрдэнэдалай сумын төвд орших Угтаал Сангийн далай хийдийн Цогчин дуган
7. Эрдэнэдалай сумын Цагаан-овоо гэдэг газар орших Үнстийн хийдийн Цогчин дуган

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал

1. Адаацаг сумын нутагт орших Зуутын хийдийн 2 ширхэг дуган
2. Баянжаргалан сумын Аргын хадны Саруулын бичигт хад хэмээх газар орших хадны бичээс
3. Баянжаргалан сумын Баянхошууны Эмээл толгойд орших хэрмийн үлдэгдэл
4. Говь-Угтаал сумын Их газрын чулууны ард орших хадны бичээс
5. Дэлгэрхангай сумын Онгийн голын эрэгт орших Хошуу хийдийн туурь
6. Дэлгэрхангай сумын Хархашаатын аманд орших хадны зураг
7. Дэлгэрцогт сумын Бага газар орших Хүннүгийн үеийн бүлшнүүд
8. Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны өвөр бэл Их тахилгатын хадны зураг
9. Дэлгэрцогт сумын Сөдөтийн амны эхний хадны зураг
10. Луус сумын Улаан нуурын ард буй Хөшөөт хэмээх газар орших хөшөө чулуу
11. Өндөршил сумын Нартын хадны Мухарын булаг хэмээх газар орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
12. Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Онгийн хийдийн туурь
13. Сайхан-Овоо сумын Онгийн голын эрэгт орших Шаазан хотын туурь
14. Хулд сумын Шарангадын нүхэн гэдэг газар орших монгол, төвд бичигтэй агуй
15. Цагаандэлгэр сумын Шар шороотын бууцны орчимд орших хөшөө чулуу
16. Эрдэнэдалай сумын Өргөн гэдэг газар орших "Суудал хад" гэдэг дөрвөлжин булш

Дундговь аймгийн соёлын биет бус өвөөс дуу хуур, гүүний айраг, хонины махны чанараараа улсдаа алдартай. Сайхан - Овоо сумын нутагт Өгөөдэй хааны өвөлжөө, Буган чулуун хөшөө, Замбага хайрхан уулын хүннүгийн үеийн бүлш, дундад зууны үед холбогдох шаазан хотын туурь, Гурвансайхан сумын нутаг Ярх уулын хуучин чулуун зэвсгийн бууц суурин, дархны газар хүрэл зэвсэг үйлдвэрлэлийн дурсгал, Дэлгэрхангай суманд Өгөөдэй хааны нас эцэслэсэн газар, Адаацаг сумын Сүм хөх бүрдэд их хаадын намаржаа байрладаг байна.

Мөн Өлзийт сумын Дэл уулын хадны зураг, Дэлгэрийн Чойрын хийд, Эрдэнэдалай сумын сангийн далай хийдийн Цогчин дуган, дөрвөлжин булш, хиргисүүрийн дурсгалууд эртний төрт улсуудын үед холбогдох булш бунхан эртний бэхлэлт цайз хэрэм зэрэг олон мянган жилийн турш хүмүүсийн аж төрж ирснийг илтгэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсээр арвин аймаг юм.

2.12 Нийгэм, эдийн засаг

Хүн ам зүй

Дундговь аймгийн суурин хүн амын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 47199 болж өнгөрсөн оноос 343 хүнээр буурч, жилийн дундаж өсөлт -0.7 хувь болжээ.

Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 0.63 байгаа нь улсын дунджаас 1.57 пунктээр бага байна.

Дундговь аймгийн хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 80.04 бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 70.92 байна. Хүн амын дундаж наслалт 74.71 байгаа нь улсын дунджаас 3.43 насаар их буюу улсын хэмжээнд 3-рт байна

2022 оны эцсийн байдлаар өрхийн тоо 14892 болж өмнөх оноос 45 өрхөөр өссөн байна. Улсын хэмжээнд 1 өрхөд ногдох хүний тоо 3.6 бол тус аймгийн хувьд 1 өрхөд ногдох хүний тоо 3.1 байна. Тухайн онд 899 эх амаржиж, 907 хүүхэд төрсөн бөгөөд өнгөрсөн оноос 205 төрөлтөөр буурсан. Энэ нь сүүлийн 15 жилийн хугацаанд хамгийн бага төрөлт бүртгэгдсэн жил байна.

Хүн амын нас баралт 306 болж өнгөрсөн оноос 40 тохиолдлоор буурч 1000 хүнд ногдох нас баралт 6.5 болжээ.

Нийт 164 хос гэрлэлтээ бүртгүүлж, 43 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Аймгийн хэмжээнд 10 үрчлэлт бүртгэгджээ.

Хөдөлмөр эрхлэлт

Ажиллах хүчний судалгааны 2022 оны жилийн эцсийн дүнгээр аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15 түүнээс дээш насны 34.4 мянган хүн байгаагийн 16.7 (48.4%) мянга нь эрэгтэй, 17.7 (51.6%) мянга нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 1.8 мянга (5.6%)-аар өссөн байна.

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 24.9 мянга (72.4%) нь ажиллах хүч, 9.5 мянга (27.5%) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 1.6 мянга (6.9%) - аар өсч , ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.1 мянга (2.3)-аар буурсан байна.

Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны стандартууд

Монгол улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 16 конвенцыг соёрхон баталжээ. Үүнд:

- Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29 дүгээр конвенц,1930;
- (Аж үйлдвэрийн салбарт) Ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 59 дүгээр конвенц, 1937 (шинэчилсэн найруулга);
- Албадан хөдөлмөрийг устгах тухай ОУХБ-ын 105 дугаар конвенц,1957;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 87 дугаар конвенц, 1948;
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай ОУХБ-ын 98 дугаар конвенц, 1949;
- Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай ОУХБ-ын 111 дүгээр конвенц, 1958;
- Тэгш шан хөлс олгох тухай ОУХБ-ын 100 дугаар конвенц, 1951
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенц, 1973;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, 1999;
